

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ:

С.АМГАЛАН

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2022.01.15

Өвт

Хөтөлбөрийн зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хүрэх үр дүн
1. Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагын дагуу мэргэшүүлэх багц сургалтад хамруулах чиглэлээр	Төрийн жинхэнэ албанад анх томилогдсон болон ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг богино болон дунд хугацааны сургалтад хамруулах	2022-2028	Жилд 12-оос багагүй төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар	Албан хаагчид мэргэшсэн байна.
	Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлагын дагуу богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн албан хаагчийг төрийн захирагааны мэргэшүүлэх багц сургалтад хамруулах		Жил бүр 4-өөс дээш албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.		
2. Ажлын байран дахь сургалтыг тасралтгүй хөгжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх	Байгууллагын “Сургалт хөгжил”-ийн төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг нарийвчлан тооцоолж тусган, хэрэгжилтийг хангах	1-р улиралд	Зардлыг төсөвт суулгасан байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар, Дотоод хяналтын багууд	“Сургалт хөгжил”-ийн төлөвлөгөөг боловсруулсан байна.
	Байгууллагын албан хаагчдын албан тушаал бүрээр зайлшгүй судлах шаардлагатай хууль, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн жагсаалт гаргаж албан хаагч бүрээр	Тухай бүр	Албан хаагч бүр судлах хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг судалсан сантай болсон байна.	ЗДТГ-ын дарга Хууль, эрх зүйн мэргэжилтэн Албан хаагчид	Албан хаагч бүрийг чадавхжуулсан байна.

	сургаж чадавхжуулах				
	Монгол бичгийг албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвших бэлтгэлийг хангаж, төрийн албан хаагчдыг сургах, суралцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах	2022-2028	Албан хаагчид монгол бичгийг албан хэргийн түвшинд зөв хэрэглэж сурсан байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар	Монгол бичгийг албан хэргийн түвшинд зөв хэрэглэж сурсан байна.
	Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, ажил мэргэжлийн холбогдолтой баримт бичгийг англи хэл болон нэн шаардлагатай гадаад хэлнээс ашиглах чадварт бие даан суралцах нөхцөл боломжоор хангах	тогтмол	Гадаад хэлний анхан шатны мэдлэгтэй болсон байна.	Албан байгууллагууд	Албан хаагчид өөрсдийн ажил мэргэжилтэй холбоотой гадаад хэлийг судалсан байна.
	Цахим засаглалын хүрээнд төрийн албан хаагчид компьютер, техник технологийг хэрэглэх, ашиглах ур чадварыг дээшлүүлэх, сургалтын арга барилыг цахим вэбинаар хэлбэрт шилжүүлэх, энэ чиглэлээр сургалтын бааз бүрдүүлэх	Жилдээ	Албан хаагч бүр программ хангамжийн ур чадвартай болсон байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар	Хурдын өндөр хүчин чадалтай компьютер, техник хэрэгслэлээр хангагдсан байна.
3. Гадаад, дотоодын их сургууль, сургалтын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, дадлагажуулах	Төрийн албан хаагчийн мэргэшил, ур чадвар, ажлын ур дүнг харгалзан тэтгэлэгт сургалтад хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх, байгууллагын зүгээс сургалтын төлбөрийн дэмжлэг, туслалцаа, цалинтай чөлөө олгох	2022-2028	Гадаад дотоодын сургалтад хамрагдаж албан хаагчид чадавхажсан байна.	ЗДТГ-ын дарга, Байгууллагын дарга эрхлэгч нар	Суралцааг байгууллагын соёл бүрэн нэвтэрсэн байна.
	Манлайлал, харилцаа,		Төрийн үйлчилгээний	Байгууллагын дарга	. Харилцаа,

	сургалтад хамруулах	хандлага, зан үйл, ёс зүй, цагийн менежмент зэрэг хувь хүний ур чадварыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг тогтмол, тасралтгүй хэрэгжүүлэх хэвшүүлэх.	2022-2028	чанарт ахиц гарсан байна.	эрхлэгч нар	хандлага, ёс зүй сургалт ойлголтууд тогтмол өгч, цагийн менежментийг бүрэн хэрэгжүүлж хэвшсэн байна.
4.	Ажлын байрны ажиллах орчин нөхцөлийг сайжруулах	Ажиллах өрөө тасалгааны засвар тохижилт, орчин үеийн шаардлагад нийцсэн техник хэрэгсэл, тавилга, эд хогшлоор хангах ажлыг шат дараатай төлөвлөн ажиллах	2022-2028	Жил бүр төлөвлөн, төсөвтөө тусган шийдвэрлэх	Байгууллагын дарга эрхлэгч нар	Ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангагдсан байна.
		Ажилтнуудын үдийн амралт болон илүү цагаар ажиллах үед нь богино хугацаанд алжаал тайлах /цай, кофе уух, сонин сэтгүүл үнших гэх мэт/ амрах өрөөг нөөц боломждоо тулгуурлан бий болгох.	2022-2028	Үдийн амралт болон илүү цагаар ажиллах үед нь богино хугацаанд алжаал тайлах амрах өрөөтэй болгох	Байгууллагын дарга эрхлэгч нар	Хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар хангагдсан байна.
5.	Ажиллах эрч хүч, урам зоригийг нэмэгдүүлэх	Байгууллага батлагдсан төсөвтөө багтаан албан хаагчдын амьдрал ахуй, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлж буцалтгүй тусlamжийг жилд нэг удаа олгох	Жил бүр	Жилд бүр албан хаагчдын тодорхой хувьд дэмжлэг үзүүлсэн байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар	Ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжид бодит ахиц гарсан байна.
		Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх, хүйсээр ялгарлан гадуурхах болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаа гарсан тохиолдолд албан хаагч,	Тухай бүр	Төрийн албан хаагчид болон ар гэр бүлийн гишүүд аливаа эрсдэл, гадны нөлөөнөөс хамгаалагдсан байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар, гэр бүлийн зөвлөл	Хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар хангагдсан байна

	түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авах. Төрийн албан хаагч өөрөө болон гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа, эмчилгээнд байдаг бол шаардлагатай тохиолдолд дэмжлэг, тусlamж үзүүлэх.	Тухай бүр	Тухай бүр дэмжлэг, тусlamж үзүүлэх.	ЗДТГ-ын дарга, Гэр бүлийн Зөвлөл	Шаардлагатай тохиолдолд албан хаагчдад дэмжлэг тусlamцааг авсан байна.
	Гэр бүлийн зөвлөл, спортын хамтлаг, сургалтын багтай болж хамт олны сонирхол, хөгжилд тулгуурласан албан бус бүлэг, нэгдлийн санаачилгыг дэмжих, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх.	2022-2028	Хамт олны хамтлаг баг бүрдүүлж амжилт гаргасан байна.	Гэр бүлийн зөвлөл	Албан хаагчдын тогтвортой суурьшилтай ажиллах, нөхцөл бүрдэнэ
6. Нийгмийн баталгаа амьдрах орчин нөхцөлийг сайжруулах	Албан хаагчдынхаа орон байрны судалгааг гарган нөхцөлийг нь сайжруулах, орон сууц, хашаа байшин, гэр барих, худалдан авахад нь хөнгөлөлттэй зээлд хамруулах, холбогдох байгууллагуудад зуучлах, гэрээ хэлэлцээрийн түвшинд ажиллах боломжийг судлах, шийдвэрлэх, дэмжлэг тусlamцаа үзүүлэх	Тухай бүр	Тухай бүр дэмжлэг үзүүлэх.	Байгууллагын дарга эрхлэгч нар	Албан хаагчдын орон байрны нөхцөл сайжирна.
	Байгууллага өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан ашгийн бусад туслах аж ахуй эрхлэх, хүнсний ногоо тариалах болон бусад боломжит дундын аж ахуйг эрхлэх, хөгжүүлэхэд техник, тоног төхөөрөмж, хөрөнгө	2022-2028	Дэмжлэг үзүүлсэн байна.	Албан байгууллагууд	Амьжиргааны түвшин зохих хэмжээгээр дээшилнэ.

	санхүүгийн тусламж дэмжлэг үзүүлэх.				
7. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшигүүлэх	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд жил бүр хамруулах	2022-2028	Албан хаагчийг үзлэг, шинжилгээ оношилгоонд хамруулсан байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар	Хөдөлмөрийн бүтээмжид ахиц гарсан байна.
	Амралт, сувилалд гэрээгээр амруулах, амралтын эрхийн бичиг болон бусад зардлын хөнгөлөлт үзүүлэх.	2022-2028	Амралтын эрхийн бичиг бусад зардлын хөнгөлөлт үзүүлэх	Байгууллагын дарга эрхлэгч нар	Амралт, сувилалтай хамтран ажиллаж хөнгөлөлт дэмжлэгт хамруулсан байна.
	Байгууллага хамт олноороо хорт зуршлаас татгалзан, амьдралын зөв хэвшил дадал, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, санал санаачилгыг дэмжих. өрнүүлэх.	Тогтмол	Хорт зуршлаас татгалзах нөлөөллийн арга хэмжээнүүд зохион байгуулах.	Байгууллагын дарга эрхлэгч нар	Суралцагч байгууллагын соёл бүрэн нэвтэрсэн байна
	Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхийг дэмжиж жилд 1-ээс доошгүй удаа идэвхтэй амралт, аялал зохион байгуулах.	2022-2028	Жил бүр зохион байгуулах	Байгууллагын дарга эрхлэгч нар	Албан хаагчдын сэтгэл ханамж, урам зориг нэмэгдэж, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэнэ.
	Дархлаажуулалтыг сайжруулах, витаминжуулах ажлыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах.	2022-2028	Дархлаажуулалтыг сайжруулах, витаминжуулах ажлыг зохион байгуулагдсан байна.	ЗДТГ-ын дарга Албан хаагчид	Нийгмийн баталгааг боломжоор хангагдсан байна.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЗДТГ-ЫН ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ

